

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.БАТБАЯР

ДХИС-ийн Ахлагчийн мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төвийн Цагдаагийн албаны тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй объектив шалтгаан нөхцөл, субъектив хүчин зүйлийг судлан түүнд үндэслэн гэмт хэргийг тодорхойлж урьдчилан сэргийлэх цаашид анхаарах асуудлын талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Хүчиндэх гэмт хэрэг, объектив шалтгаан нөхцөл, субъектив хүчин зүйл.

Оршил

Хүчиндэх гэмт хэрэг нь ихэвчлэн ахуйн хүрээнд далд аргаар үйлдэгдэн хохирогчийн бие махбод, сэтгэл зүйд хүнд хор уршиг учруулдаг. Тухайн хэргийг шалгаж шийдвэрлэх явцад хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийн баталгаа, хувийн нууц мэдээлэл гээд олон талын хамгаалалт зөрчигддөг. Хүчиндэх гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл/¹ нь 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйл/² -тэй объектив талын шинж болох үйлдэл, субъектив талын шинж болох гэм буруугийн хэлбэрээрээ төстэй боловч объект, объектив талын нэмэгдэл шинж болох үйлдлийн арга, субъектив талын шинж болох хохирогчийн хүсэл зориг, гэмт хэрэг үйлдсэн хүний насаар нь ялгаж зүйлчилнэ. Хүчиндэх гэмт хэргийн объект нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал байдаг бол 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн тухайд нийгмийн ёс суртахуун, 16 насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн бойжилт, бие бялдрын зөв хөгжил байдаг³.

Үндсэн хэсэг

Хүүхэд хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг юуны өмнө дотоод буюу субъектив, гадаад буюу объектив хүчин зүйл гэж салгаж үзнэ.

Объектив хүчин зүйлд:

Ядуурал, ажилгүйдэл, ахуйн хүрээний архидалт, сургууль завсардалт, эцэг эхийн хайр халамж дутах, гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн хор аюулын шинж чанар, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчийн таагүй харьцаа, хараа хяналт, найз нөхдийн сөрөг нөлөө, хяналтгүй цахим хэрэглээ, хүүхдийн суурь хүмүүжил, хяналтгүй зочид буудал зэрэг хамаарна⁴.

Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл:

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь ажилгүйдэл, архидалт, ядуурлаас гадна эцэг эхийн хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, ахуйн хүрээний архидалт, цахим орчны хяналтгүй хэрэглээ, хүүхдийн биеэ хамгаалах чадваргүй байдал, гэнэн итгэмтгий зан байдал, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрэн бүрдэж, үйл ажиллагаа нь жигдрээгүй байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн

¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл. УБ., 2017.

² Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйл. УБ., 2017.

³ Монгол Улсын Эрүүгийн хууль. 12 дугаар бүлэг. УБ., 2017.

⁴ Г.Гантөмөр "Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол" 2011.

байдал /Боловсролын түвшин, хувь хүний төлөвшил/ гэх мэт шалтгаан нөхцөл нөлөөлж байна.

Субъектив хүчин зүйлд:

Сэтгэл зүйн ерөнхий шинж, төлөвшлийн үе, сониуч гэнэн зан, өөрийгөө хэт үнэлэх хандлага, бусдын нөлөөнд хэт амархан автах байдал, оюун санаа, сэтгэл хөдлөл, хүсэл зориг, 10-14 насны хүүхдийн хувьд сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, өөрийн гэсэн үзэл бодол тогтоогүй байдаг учир адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах, чадавхгүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн онцлог мөн хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мөнгө шаардлагатай болсон, зочид буудал, гэмт хэрэг үйлдсэн хүний ажлын байранд очсон, тээврийн хэрэгслээр зугаалсан, ажил, хөдөлмөр эрхлэх нэрээр садар самуун явдалд татагдан биеэ үнэлсэн, бусдаас тусламж хүсэх боломж байсаар байтал тусламж аваагүй зэрэг хохирогчийн буруутай үйлдэл цөөнгүй байна. Эдгээр нөхцөл байдлын цаана гэр бүлийн таагүй орчин, эцэг, эхийн хараа хяналт сул, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл байгааг анхаарах нь зүйтэй. Судалгаанаас үзэхэд, 12 настай охин ажил хийж байгаа нэрээр гэртээ нэг сар орчим ирээгүй байхад эцэг, эх нь хайгаагүй байх, хойд эцэгтээ хүчиндүүлсэн охин нэгэнт хүчиндүүлсэн гэсэн шалтгаанаар бусад хүнтэй төлбөртэй бэлгийн харьцаанд орсон зэрэг өөрөөс хамааралтай зүйлүүд орно¹.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгсдийн талаар болон бага

насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэгтний гаж дон, зуршлыг мэргэжлийн эмч, эрдэмтэн, судлаачид хэрхэн дүгнэсэн талаар холбогдох материалуудыг судлахад: Бэлгийн

хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийн дийлэнх нь хүчирхийллийн дарамтад өссөн, бие бялдар болон царай дүр төрхөөс болж үе тэнгийнхэндээ гадуурхагддаг, өөрийгөө хамгаалах чадваргүй, бэлгийн анхны харьцаанд сөрөг байдал үүссэнээс өөртэй итгэлгүй болсон, түүнчлэн эмэгтэй хүнтэй дотно харьцаа үүсгэж чаддаггүй, огцом ууртай, нийгэмд болон гэр бүлдээ өөрийн эзлэх байр суурь үгүй байдаг зэрэг энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсдийн нийтлэг шинжийг тодорхойлсон² байна. Прокурорын байгууллага салбар салбарын мэргэжлийн судлаачдын баг бүрдүүлж, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг олон талаас нь судалсан судалгааг авч үзлээ.

Тухайлбал, хүчирхийлэгчээс хүчирхийлэгч төрдөг гэдэг нь судалгаагаар батлагдсан байна. Өөрөөр хэлбэл бага насны хүүхэд хүчирхийлсэн этгээдийн хувийн шинж чанарыг тодорхойлохын тулд өргөн цар хүрээтэй асуумж боловсруулсан. Иймд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хаалттай хорих ангид ял эдэлж байгаа 10 ялтанг сонгон сэтгэл судлаачийн хамт ярилцлага хийсэн. Ингэхэд эдгээр ялтангийн 8 нь анх удаа бэлгийн харьцаанд орохдоо биеэ үнэлэгчтэй хавьтсан, 5 нь бага насандаа бэлгийн халдлагад өртөж байсан, 9 нь эцэг, эх нь салсан байсан³. Хүчиндэх гэмт хэргийн хувьд бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгохгүй байгааг далимдуулж, хүч

¹ С. Нарангэрэл “Эрүүгийн эрх зүй” 84 дэх тал. УБ., 2007.


² Монгол Улсад 2012-2016 онд үйлдэгдсэн “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг

судалсан суурь судалгаа” тайлан. УБ., 2019. 183 дугаар тал

³ Улсын Ерөнхий Прокурорын сургалт судалгааны төвийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах хүрээлэнгийн захирал, ахлах прокурор, Ph.D Б.Өнөрмаагийн судалгаа.

хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглүүлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах, хууран мэхлэх зэрэг аргаар ихэвчлэн үйлдэгдсэн байна. Түүнчлэн эцгийнхээ зодуур дунд өссөн, бэлгийн хүчирхийллийн утга агуулга бүхий киног бага насандаа үздэг байсан зэрэг байна. Судалгаанд хамрагдсан нийт эрүүгийн хэргийн 70 хувь нь бэлгийн амьдралын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс олж авсан байдаг байна. 52 хувь нь гэмт хэрэг үйлдэхдээ согтууруулах ундаа хэрэглэсэн, 42 хувь нь өмнө нь ял шийтгэл эдэлж байсан хүмүүс байсан. Үүнээс үзэхэд гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан, нөхцөл нь дан ганц ажилгүйдэл архидалт, ядуурлаас гадна, хувь хүний төлөвшил, гэр бүлийн хүмүүжил нөлөөлж байна. Мөн гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа зэрэг нь

бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Судалгаанаас үзэхэд, өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн тохиолдол 2.9 хувь, эзэлж байна. Харин дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 19.1 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг эзэлж байна. Тухайлбал, гэр бүл салж, хоёр дахь амьдрал зохиосонтой холбоотойгоор өөрийн төрсөн хүүхэд биш гэсэн шалтгаанаар бага насны хүүхдийг хүчиндсэн, ээж нь өөрийн 11 настай охиноо дүү нарынх нь хамтаар хойд эцэгтэй нь хаяж явснаас шалтгаалан эцэг, дагавар охин хоёр эхнэр нөхөр шиг амьдарч, бэлгийн харьцаанд удаан хугацаанд орсон зэргийг дурдаж болно¹. Ийм нөхцөлд өссөн хүмүүс бусдыг үзэн ядах, хэн нэгнээс эргээд хариу авах гэж хүсэл аажмаар бий болж улмаар өөрийгөө хамгаалах чадваргүй, тухайлбал бага насны хүүхдийг хүчирхийлсэн тохиолдол гарч байгаад анхаарлаа хандуулах цаг болсон. *Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүйсийн харьцаа, хувиар² авч үзвэл:*



Эх сурвалж: Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ бодлогын судалгааны тайлан.

Орчин нөхцөлийн хувьд 72 хувь нь амьжиргааны нөхцөлөөс доогуур

эсвэл дөнгөж дээгүүр өрхөд мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй,

¹ Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ бодлогын судалгааны тайлан. УБ., 2019.

² Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ бодлогын судалгааны тайлан. УБ., 2019.

боловсролын түвшин бага, эрхэлсэн тодорхой ажилгүй, хүүхдэдээ тавих хараа, хяналт байхгүй, архины хэрэглээ өндөр өрхөд хүчиндэх төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна. Үүнээс гадна дээр дурдсан нөхцөл, шалтгааны улмаас сэтгэцэд нь өөрчлөлт орох буюу хүчирхийлэл үйлдэх эмгэгтэй болох шалтгаан болж байна. Мөн сургуулийн амралтын үед бага насны хүүхдийг хүчиндэх төрлийн гэмт хэрэг их үйлдэгдэж байна, хүүхдийг хараа хяналтгүй орхих, хүүхдүүд цахим орчинд мэдээлэл олж авах, чатаар хүнтэй танилцах зэрэгт хяналт тавьж чадахгүй байгаа нь том нөхцөл болж байна. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садангийн хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 38.2 хувь нь хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол 30.9 хувь, нь хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ. Судалгаанд хамрагдсан нийт гэмт хэргийн 48 хувь нь ургийн хүчирхийлэл буюу төрсөн болон хойд эцэг эх, хамаатан садандаа хүчиндүүлсэн тохиолдол байна¹.

Ургийн хүчирхийлэл нь удмын сан болон нөхөн үржихүйд

ноцтой аюул дагуулдаг гэмт хэрэг юм. Ураг төрөлдөө хүчиндүүлсний улмаас жирэмслэх, үр хөндүүлэх, дахиж жирэмслэх боломжгүй болох гээд маш олон хортой үр дагавар дагуулдаг. Бага насны хүүхэд халдлагад өртсөн тохиолдол бүрийн цаана насанд хүрсэн хүний шууд буруутай үйлдлээс гадна салбар хоорондын уялдаа холбоогүй зарим тохиолдолд сэтгэл дутсан шууд бус шалтгаан байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Дараагийн нэг асуудал бол хуулиар бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хохирлыг ангилж тогтоодоггүй, зөвхөн бие махбодод учирсан хохирлын зардал гэж үзэн эмнэлэгт үзүүлсэн зардлыг л гаргуулдагтай холбоотой юм. Тиймээс хохирогчийн сэтгэл зүйн гэмтэл, эмгэг болон түүнийг эмчлэхэд гарах зардлыг тооцдог олон улсын стандартыг нэвтрүүлж, хэрэг шалгагдаж эхэлсэн үеэс хүүхдийг эрүүл мэндийн даатгалаар нь сэтгэл зүйн болон нөхөн сэргээх эмчилгээнд нэн даруй хамруулдаг болгох хэрэгтэй². Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болдог. Судалгаанаас үзэхэд, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садангийн хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол цөөн байна.

¹ Улсын Ерөнхий Прокурорын сургалт судалгааны төвийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах хүрээлэнгийн захирал ахлах прокурор, PhD Б.Өнөрмаа ярилцлага – УБ., 2019.

² Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ-УБ., 2019.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний насыг хувиар авч үзвэл:



Эх сурвалж: Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ бодлогын судалгааны тайлан.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний боловсролын түвшин, хувиар¹ авч үзвэл:



Эх сурвалж: Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ.

Гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг бид олон жилийн турш ажилгүйдэл, ядуурал, архидалт гэсэн 3 том нийгмийн сөрөг үзэгдлээр тодорхойлж ирсэн. Ерөнхий агуулгаараа дээрх хүчин зүйлс нь гэмт хэргийн гаралтад нөлөөлдөг нь үнэн боловч тодорхой төрлийн гэмт хэрэгт тухайн хүний төлөвшил, өссөн орчин, гэр бүлийн хүмүүжил, боловсрол, сэтгэхүй, хандлага гээд олон хүчин зүйлс нөлөөлж байдаг. Гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, нөхцөлийг тогтоосноор бид эрсдэлтэй бүс, хүнд тавих хяналтаа сайжруулж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх боломжтой.

Үүнээс дүгнэн үзвэл хүүхэд гэр бүлийн хүрээнээс гадна сургуулийн орчинд нийгэмшин хөгжиж бие хүн болж төлөвшдөг байна. Сургууль бол хүүхдийн сурах, боловсрох, харилцах, оюун ухаанаа хөгжүүлэх, хүмүүжих, төлөвших, энэ төрлийн

байгаагаас хүүхэд гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн хохирогч болох шалтгаан болж байна. Мөн ерөнхий боловсролын сургуульд эрх зүйн хичээл бага цагаар ордог, мэдлэг муу эзэмшүүлдэг нөхцөл байдлаас болж хүүхдүүд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болох нь их байдаг байна. Тухайлбал, амьдралын туршлагагүй, аливаа үйл явдлын мөн чанарт хандах чадвар мөхөс, бусдыг дуурайх, тэдний харш үзэл бодол, үйл ажиллагааг ойлгохгүй уруу татагдах, эцэг, эх болон ойрын хүмүүсээс тэдэнд тавих хараа хяналт сул, тэнэмэл зэрэг нөхцөл байдлууд нөлөөлдөг байна.

Хүүхдийн эрхийг хангах баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг, зарчмын шинжтэй хамгийн чухал үзэл санаа бол хүүхдийн эрхийг нэн тэргүүнд ханган хамгаалах зарчим юм¹. Энэ зарчим нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл 2 дахь хэсэгт

¹ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. УБ., 2016.

зааснаар төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангахыг эрмэлзэх зарчмыг баримталана¹. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаад анхаарал хандуулж, хүүхдийн амьдрах, хөгжих эрхийг нь хэрэгжүүлэх, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх ажилд онцгой ач холбогдол өгөх цаг болсон байна. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн гол арга бол хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн хөгжлийг түргэтгэх өргөн хүрээтэй арга хэмжээ авах, ядууралд анхаарлаа хандуулах явдал юм.

Олон улсын туршлагаас үзэхэд, хүчингийн гэмт хэрэгт хохирсон хүүхдүүдийг хуулийн байгууллагын хараа хяналтад байлгахгаас илүү тэдэнд нийгмийн халамжийн зохих үйлчилгээг үзүүлэх нь үр дүнтэй байдаг байна.

Иймээс манай улсад хүүхдүүдийг хараа хяналтын дор байлгадаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг төрийн бодлогоор ихээхэн дэмжих нь чухал юм. Мөн төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, эцэг эхчүүдийн хариуцлагыг дээшлүүлэх, нийгэм дэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, сургууль завсардах шалтгааныг илрүүлэн арилгах арга хэмжээ авах хэрэгтэй юм.

“Монгол Улсын Үндсэн Хууль”-д заасан журамт үүргийн нэг болох үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргийг үндсэн үүрэг болгон хуульчилбал эцэг, эхээс хүүхдэдээ тавих хяналт сайжирч хараа хяналтгүй хүүхэд, гэмт хэрэгт холбогдох хүүхдийн тоо эрс буурах үндэслэл байгаа юм. Хүүхдээ хүмүүжүүлж чадаагүй гэмт хэрэгт холбогдуулсан, гудамжинд гаргасан эцэг, эхчүүдэд хуулийн дагуу арга хэмжээ авдаг эрх зүйн

тогтолцоотой болох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Дүгнэлт

1. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход, энэ төрлийн гэмт хэргийн урьдчилан сэргийлэх талаарх ойлголт, хүүхдэд, нийгэмд учрах хор уршгийн талаар ойлголт дутмаг, хайнга хандаж байгаагаас шалтгаалж байна. Тухайлбал, эцэг, эхийн хүүхдэдээ тавих хараа хяналтгүй байдал, гэртээ эсхүл айлд орхих, хойд эцэгт нь үлдээх, ядуурал, ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн тогтворгүй байдал, 10-14 насны хүүхдийн хувьд сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, эдийн засгийн хувьд бусдаас хараат байдалтай байгаа нь бусдад амархан итгэх, хууртах, өөрийн гэсэн үзэл бодол тогтоогүй, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн онцлог, биеэ хамгаалах чадваргүй байдал, нийтийн сүлжээний хяналтгүй байдал зэрэг объектив, субъектив хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж байна.

2. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан нөхцөл болж байна. Хойд эцэгтээ удаан хугацаагаар хүчиндүүлсэн бага насны хүүхдүүдийн ихэнх нь хамгийн анхны хүчирхийллийн дараа ээждээ хэлсэн байх боловч ээж нь үнэмшээгүй, нөхөртөө итгэсэн зэргээс гадна мөн өөрөө өдсөн, илт зөвшөөрсөн, дахиж хүссэн, чатаар харилцсан, нүцгэн эсвэл биеийн аль нэг хэсэг гарсан зургаа явуулсан гэх мэт хохирогчийн буруутай үйлдлүүдээс болж энэ төрлийн гэмт

¹ Хүүхдийн эрхийн хамгаалах тухай хууль.

4.1.2 хэсэг. УБ., 2016.

хэргийн давтан, нуугдмал золиос болох гол шалтгаан нь болж байна. Үүнийг дүгнэн үзвэл бэлгийн харилцаа, хэрхэн урьдчилан сэргийлэх, хэнд хандах зэрэг мэдлэг, боловсрол дутмаг гэж үзлээ.

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, /боловсролын түвшин, эрхэлсэн ажилгүй, хувь хүний төлөвшил, ёс суртахуун/ нийгмийн гажуудал, ихэвчлэн хотын захын дүүрэг, гэр хорооллын ойр орчмын сургуулийн захиргаа, боловсролын байгууллагаас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагатай хамтын ажиллагаа дутмаг энэ чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй, төрийн бодлогыг дутмаг хэрэгжүүлдэг улмаас эрсдэлийг нэмэгдүүлж байна. Нөгөө талаар хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал тулгамдсан хэвээр байгааг харуулж байна. Иймд бага насны хүүхдэд энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар насанд нь тохирсон ойлголт өгөх сургалтын хөтөлбөрт тусгаж өгөх шаардлагатай гэж үзлээ.

Санал

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг бууруулахад ач холбогдолтой дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын хүнд гэмт хэрэг, мөрдөн шалгах хэлтэс, бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн судалгааг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран хийж, мэдээллийн сан бүрдүүлэн, хяналт тавих, тэдгээр хүмүүсийг бэлгийн дур хүсэл бууруулах, сэтгэц, зан үйлийн сайн дурын эмчилгээнд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах;

2. Өсвөр насны хүүхэд, оюутан залууст биеэ авч явах соёл, аюулгүй байдлаа хэрхэн хангах,

бэлгийн чиг хандлага, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох сургалтыг ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаж хичээл сургалтыг зохион явуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахад төрөөс нэлээдгүй анхааралдаа авч, бодлого хэрэгжүүлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл зэргийг тогтмол явуулах;

3. Энэ төрлийн гэмт хэргийн давтан үйлдэгдэхээс сэргийлж, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг ар гэрийн хамт өөр аймаг, сум, дүүрэгт нүүлгэн шилжүүлж, нууцлалыг чандалж, шинэ ертөнц нээж өгдөг байх. /нүүлгэсэн тохиолдолд төр засгаас эцэг, эхийг ажлын байраар хангах;

4. Садар самуун явдал, биеэ үнэлэх, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээнт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернэт орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ-УБ., 2019.

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. УБ., 2016.

- Улсын Ерөнхий Прокурорын сургалт судалгааны төвийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнгийн захирал ахлах прокурор, PhD Б.Өнөрмаа судалгаа УБ., 2019.

- Монгол Улсад 2012-2016 онд үйлдэгдсэн “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсан суурь судалгаа” тайлан. УБ., 2019.

- Гантөмөр Г. “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол” 2011.

- Нарангэрэл С. “Эрүүгийн эрх зүй” 2007.

- Монгол Улсын Эрүүгийн хууль 2017.

- Бат-Очир Л, Гантулга С, Энхболд Б. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг. УБ., 2011.

- Гантулга С, Энхболд Б. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018.

- Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ., 2011.